

Түүх 3 : Иосеф 2

Библийн эшлэл
[Эхлэл 50:20]

Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө түүнийг сайнаар эргүүлсэн юм.

Египетийн сайд болсон Иосеф хааны дараа орох эрх мэдэлтэй хүн болжээ.

Иосефийг сайн болсон эхний долоон жил нь өнтэй сайхан жил болсонн бөгөөд ургац арвин, хүнс элбэг дүүрэн байв.

Египетийн түшмэдүүд Иосефийн хэлсний дагуу агуулахуудыг үр тариагаар дүүртэл хураажээ.

Өнтэй сайхан долоон жил дуусаж, гантай жилүүд эхлэв.

Хур бороо ороогүй учир тариан түрүүнүүд хатаж хорчийжээ. Гэсэн ч мэргэн ухаантай Иосеф өнтэй жилүүдэд үр тариаг хураан хадгалсан учир Египетийн ард түмэнд өлсөх, зовлон ирсэнгүй.

Иосеф ард түмэндээ нөөцөлсөн үр тарианаас хуваан өгч байлаа.

Египетэд үр тариа их байгаа тухай мэдээ холын нутагт ч тархав.

Ган зудаас болж Иаковын гэр бүл амьдарч байгаа Канаан нутаг ч бас өлсгөлөнд нэрвэгдсэн байлаа.

Нэгэн өдөр Иаков хөвгүүдээ дуудаж ингэж хэлэв.

“Египетэд очоод үр тариа худалдаж аваад ир” гэж хэлэв.

Арван ах нь бага дүү Бениаминаа гэртээ үлдээгээд, Египет рүү үр тариа авахаар явцгаав.

Египетэд ирээд, ах нар нь Египетийн сайдад хүндэтгэн мөргөв.

Тэдний хэн нь ч дүү Иосефоо таньсангүй. Харин Иосеф бол ах нараа шууд таньж байлаа.

Иосеф ах нараа хараад уйлах гэсэн боловч биеэ барьж, ширүүн дуугаар зэмлэв.

“Та нар манай нутгийг тагнахаар ирсэн түршуулууд биш үү?”


Ах нар нь ингэж хариулав. “Үгүй ээ, эзэн минь.

Бид үр тархиа худалдаж авахаар Канаан нутгаас ирцгээлээ.”

гэж хэлэв. Иосеф дахиад тэд нараас асуув. “Та нар ах дүү хэдүүлээ вэ?”

“Бид бүгд арван хоёулаа, бага дүү маань гэрт байгаа, харин нэг дүү маань алга болсон.” гэж ах нар нь хариулав.

Тэдний үгийг сонсоод Иосеф, бага дүү Бениаминыг их санажээ.



Иосеф тэдэнд ингэж хэлэв. “Гэхдээ та нар дундаас нэг хүн нь энд үлдээд бусад нь нутагруугаа буцаад дүүгээ авчир. Хэрэв тэгэхгүй бол үлдсэн хүн нь үхэх болно шүү.”

Ах нараас нь Симеон үлдэж, бусад нь үр тариагаа аваад Канаан уруу буцжээ.

Хэсэг хугацааны дараа Иосефын ах нар бага дүү Бениаминаа дагуулаад дахин Египетэд иржээ.

Иосеф, дүүгээ хараад маш их баярласан ч ах нараа сорихоор болов. Бениамины авч явах үр тариа хийсэн уутанд нь нэгэн мөнгөн аягыг нууцаар хийв.

Тэгээд мөнгөн аяга хулгайлсан хэргээр гүтгэн Бениаминыг аваад үлдэв.

Ах нар нь өвдөг сөгдөн түүнээс ингэж гуйв.

“Хөгшин аав минь Иосеф хүүгээ алдсанаас хойш ихэд гунигласан.

Одоо Бениаминыг хүртэл алдчихвал түүнд юу гэж хэлэх билээ” гэгцгээв.

Ах нар нь толгой гудайлган чин сэтгэлээсээ уучлалт гуйж байлаа.

Бага дүүгээ хайрлаж байгаа ах нарынхаа байдлыг харсан Иосефын сэтгэл зөөлөрч байв.

Мөн ах нар нь аавыгаа болон дүүгээ гэх сэтгэлтэй байгааг мэдэрч байв.

Иосеф сэтгэлээ барьж чадалгүй ах нараа тэврэн ихэр татан уйлж, тэднийг уучилжээ.

Үхсэн гэж бодож байсан дүү нь амьд байгааг хараад, ах нар нь гайхан цочирджээ.

Тэд Египетийн сайд болсон дүүгээ хараад, өнгөрсөн явдлаасаа болоод Иосефын өмнө үхтэлээ айж чичирч байлаа.

Гэвч Иосефийн хувьд ах нарыгаа чин сэтгэлээсээ уучилж, нулимсаа тэвчин ядан байлаа.


- **Дараах библийн эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 50:20)**

Бурхан түүнийг сайнаар эргүүлсэн юм.



Үйл ажиллагаа 1.

Египтийн ерөнхий сайдын толгойдоо өмсдөг малгайг гоёмсогоор будаж, хайчлаад Иосефийн толгой дээр наагаарай. (Хэрэглэгдэх материал: Өнгийн харандаа, хайч, цавуу)



Жишээ зураг.



